



МОНГОЛ УЛСЫН  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 15/210

Улаанбаатар хот

Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба  
тодорхойлолт 08-д нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт 08”-ын хоёрдугаар хавсралтад энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

2.Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар нэмэлт, өөрчлөлт орсон ажил мэргэжлийн мэдээллийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Аж ахуйн нэгж, байгууллагуудад энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан ажил, мэргэжлийн ангиллыг үндэслэн ажил мэргэжлийн жагсаалт, ажлын байрны тодорхойлолт боловсруулахыг зөвлөсүгэй.

САЙД



Т.АЮУРСАЙХАН

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
2022 оны 22 дугаар сарын 22 ны өдрийн  
А/Б/210 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**Нэг. Шинээр нэмэх ажил мэргэжил /38/**

- 1121-50 Газар, хэлтсийн дэд захирал /дэд дарга, орлогч дарга/
- 1213-14 Эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчны дарга, эрхлэгч /менежер/
- 1219-17 Газар, хэлтсийн дарга, эрхлэгч /менежер/
- 1439-17 Хэрэглэгчдэд үйлчлэх, түгээх төвийн дарга
- 2113- 51 Аналитик химич
- 2114-33 Геохимич
- 2141-49 Инженер, үйлдвэрлэлийн
- 2142-60 Инженер, барилга угсралтын мэдээлэл холбоо, дохиоллын
- 2142-61 Инженер, барилгын материалын иж бүрэн автомат удирдлагатай технологийн шугамын
- 2143-16 Мэргэжилтэн, дахин боловсруулалтын
- 2143-17 Хаягдал боловсруулах технологийн инженер
- 2149-17 Инженер, эрүүл мэнд, аюулгүй байдлын
- 2152-32 Инженер, барилгын материал үйлдвэрлэлийн автоматжуулалтын
- 2161-14 Интерьер архитекторч /дизайнер/
- 2165-27 Зураг зүйч
- 2165-28 Газар зүйн мэдээллийн системийн мэргэжилтэн
- 2413-14 Санхүүгийн шинжээч
- 2413-15 Хөрөнгө оруулалтын шинжээч
- 3112-38 Техникч, гүүр, тунелийн
- 3132-13 Операторч/Машинч, бохир усны насос станцын
- 3132-15 Техникч/Механикч, ус цэвэршүүлэх үйлдвэр, станцын
- 3313-16 Нягтлан бодох бүртгэлийн туслах

5245-13	Ус түгээгч
7112-19	Өрөгч, угсрагч, барилгын
7112-23	Барилгын хэв хашмал угсрагч
7113-10	Чулуучин
7119-23	Барилгын буулгалт /нураалт/-ын ажилтан
7122- 21	Хулдаас, чулуу, плитагаар шаллагч
7123-20	Тааз суурилуулагч, угсрагч
7213-10	Нимгэн төмөрчин
7411-13	Цахилгаан хөдөлгүүр задлагч, ороогч
8114-23	Операторч, эргэх зуух, тээрмийн, хөргөх төхөөрөмжийн
8114-24	Барилгын материалын үйлдвэрийн дамжлагын операторч /чулуунцарын/
8142-23	Хуванцар хоолойн машины операторч
8332-20	Жолооч, ариутгах татуургын машины
8332-21	Операторч, тусгай тоноглол бүхий машины
8342- 28	Операторч, скреперын /хусагчийн/
9313-14	Барилгын газар, шуудууны ажилтан, нүх ухагч нягтруулагч

#### Хоёр. Өөрчлөлт оруулах ажил мэргэжил /64/

№	Өмнөх нэршил	Нэршилд орох өөрчлөлт
1	1212-13 Дарга, эрхлэгч /менежер/, алба, газар, хэлтэс, тасгийн /ажилтан элсүүлэх, сонгох/	1212-13 Дарга, эрхлэгч /менежер/, хүний нөөцийн
2	1324-11 Дарга, эрхлэгч /менежер/, алба, хэлтэс, тасгийн /логистикийн менежер/	1324-11 Дарга, эрхлэгч /менежер/, логистик, түгээлтийн
3	1324-13 Дарга, эрхлэгч /менежер/, алба, хэлтэс, тасгийн /хангамж, түгээлтийн/	1324-13 Дарга, эрхлэгч /менежер/, хангамжийн
4	2114-15 Геологич, инженерийн	2114-15 Геологич, инженер
5	2142-11 Инженер, барилгын технологийн	2142-11 Инженер, барилга байгууламжийн бүтээцийн технологийн
6	2142-16 Инженер, иргэний барилгын	2142-16 Инженер, иргэний ба үйлдвэрийн барилгын



7	2142-17 Инженер, зам гүүрийн	2142-17 Инженер, замын
8	2142-31 Инженер тунелийн	2142-31 Инженер, гүүр, тунелийн
9	2142-32 Инженер, ус хангамжийн	2142-32 Инженер, ус хангамж, ариутгах татуургын
10	2142-41 Инженер, усан дахь барилгын	2142-41 Инженер, усны барилга байгууламжийн
11	2142-44 Инженер, цэвэрлэх байгууламжийн	2142-44 Инженер, цэвэрлэх байгууламжийн технологич
12	2142-48 Инженер, барилгын бүтээц, эдлэлийн технологич	2142-48 Барилгын материал үйлдвэрлэлийн технологич инженер
13	2142-52 Инженер, агааржуулалт, агаар сэлгэлтийн	2142-52 Инженер, халаалт, агаар сэлгэлт, агааржуулалтын
14	2144-31 Механикч, инженер, агааржуулалтын	2144-31 Инженер, хөргөлт, агааржуулалтын
15	2146-22 Маркшейдер, ил уурхайн	2146-22 Инженер, маркшейдер
16	2411-12 Ахлах нягтлан бодогч	2411-12 Нягтлан бодогч
17	3112-11 Техникч, иргэний барилгын	3112-11 Техникч, иргэний ба үйлдвэрийн барилга байгууламжийн
18	3112-12 Техникч, дулаан хангамж, агааржуулалтын	3112-12 Техникч, халаалт, агаар сэлгэлтийн
19	3112-13 Техникч, ариутгах татуургын	3112-13 Техникч, ус хангамж, ариутгах татуургын
20	3112-15 Техникч, хөрс, суурийн	3112-15 Техникч, хөрс, суурь судалгааны
21	3112-22 Техникч, гидролигийн	3112-22 Техникч, гидрогеологич
22	3112-23 Техникч, байгууламжийн чанар, стандартын	3112-23 Техникч, байгууламжийн чанар, стандарт, хяналтын
23	3112-25 Техникч, байгууламжийн хийцийн	3112-25 Техникч, барилга байгууламжийн хийцийн
24	3112-34 Төсөвчин /иргэний барилга, байгууламжийн/	3112-34 Техникч, төсөв, үнэ бүрдлийн
25	3123-11 Иргэний барилга угсралтын байцаагч	3123-11 Иргэний ба үйлдвэрлэлийн барилгын ерөнхий хянагч
26	3132-12 Операторч, ус шахуургын станцын	3132-12 Операторч/Машинч, цэвэр усны насос станцын
27	3132-13 Операторч, ус цэвэрлэх байгууламжийн	3132-14 Операторч/Машинч, шингэн хог хаягдал боловсруулах, ус цэвэрлэх байгууламжийн, төхөөрөмжийн
28	7112-11 Угсрагч, угсармал төмөр бетон бүтээцийн	7112-11 Угсрагч, ган болон угсармал төмөр бетон бүтээцийн
29	7114-18 Цементен гадаргуу өнгөлөгч	7114-18 Бетон хийцийн засалч
30	7115-12 Өнгөлгөөний мужаан	7115-12 Заслын мужаан
31	7119-21 Угсрагч, угсармал байшин, барилгын	7119-21 Барилгын гадна дотор хуурай хийц угсрагч
32	7119-22 Угсрагч, барилгын шатны	7119-22 Барилгын ажлын түр шат, тавцан угсрагч
33	7122-13 Өнгөлөгч, мозайкаар	7122-13 Мозаик шал хийгч
34	7122-20 Хивсэнцэр наагч	7122-20 Хивсэн материалаар шаллагч
35	7123-12 Шаварчин, барилгын чимэглэл	7123-12 Шавардлага өнгөлгөөний ажилтан



36	7123-15 Шаварчин, барилгын чимэглэлийн	7123-15 Гадна гадаргууны шавардагч
37	7124-13 Тусгаарлагч, ажилчин барилгын	7124-13 Барилгын ус чийг тусгаарлагч
38	7126-11 Сантехникч, хоолой угсрагч	7126-11 Сантехникч, шугам хоолой угсрагч
39	7126-13 Сантехникч-термист, явуулын дулааны төхөөрөмжийн	7126-13 Сантехникч, дулааны төхөөрөмжийн
40	7126-16 Сантехникч, дамжуулах хоолойн /ариутгах/	7126-16 Сантехникч, ариутгах татуургын
41	7126-17 Сантехникч, дамжуулах хоолойн /усан хангамжийн/	7126-17 Угсрагч, халаалт, агаар сэлгэлтийн системийн
42	7126-24 Угсрагч, гадна дамжуулах хоолойн	7126-24 Угсрагч, гадна сантехникийн дамжуулах шугам ба хийн хоолойн
43	7126-26 Угсрагч, сантехникийн систем, тоног төхөөрөмжийн /салхивчийн/	7126-26 Угсрагч, дотор сантехникийн систем, угсралтын /халаалт, цэвэр ус, ариутгах татуурга/
44	7126-30 Угсрагч, системийн	7126-30 Шугам хоолойн засвар үйлчилгээний ажилтан
45	7127-11 Механикч, агааржуулалтын тоног төхөөрөмжийн	7127-11 Механикч, хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмжийн
46	7131-13 Будагчин засалч ханын	7131-13 Будагчин, засалч хана, тааз, шалны
47	7131-15 Будагчин, барилгын	7131-15 Шүршиж будагчид, лакдагчид
48	7133-15 Цэвэрлэгч, байшин, барилгын гадны орчин	7133-15 Барилга байгууламжийн гадаргуу цэвэрлэгч
49	7211-12 Автоклавч, даралтаар цутгах	7211-12 Операторч, хэвэнд цутгах төхөөрөмжийн
50	7212-19 Гагнуурчин, цахилгаан 7212-20 Гагнуурчин, цахилгаан-хийн	7212-19 Гагнуурчин, цахилгаан ба хийн
51	7212-29 Огтлогч, лазерийн	7212-29 Үл эвдэх сорилын гагнуурчин
52	7214-12 Бэлтгэгч, металл загвар	7214-12 Металл хийц бэлтгэгч, угсрагч
53	7215-13 Цамхаг оосорлогч	7215-13 Цамхагт краны оосорлогч
54	7223-28 Суурилуулагч, металл боловсруулах машины	7223-28 Металл боловсруулах суурь машины тохируулагч, операторч
55	7231-18 Механикч, тракторын	7231-18 Хүнд машин механизмын механикч
56	7231-19 Тохируулагч, хөдөлгүүрийн /машины/	7231-19 Автомашины хөдөлгүүрийн засварчин, моторчин
57	8113-16 Цооног өрөмдөгч	8113-16 Операторч, өрмийн машины
58	8182-11 Операторч, уурын тогооны	8182-11 Операторч, уурын тогоо, халаалтын зуухны
59	8212-12 Цахилгаан төхөөрөмж угсрагч	8212-12 Цахилгаан тоног төхөөрөмжийн угсрагч
60	8332-12 Операторч, хүнд даацын дугуйт ачигчийн	8332-12 Операторч, хүнд даацын авто машины
61	8342-11 Тракторч	8342-11 Газар шороо, зам засварын болон түүнтэй адилтгах машины операторч
62	8342-12 Гадас суулгагч	8342-12 Гадас суулгагч машины операторч
63	8342-13 Жолооч, бульдозерийн	8342-13 Операторч, бульдозерийн

64	8343-11 Операторч, салдаг гүүр, зөөврийн шатны машин, канат конвейрын, гүүрэн краны	8343-11 Операторч конвейрын гүүрэн краны, агуулахын, өргүүр сагстай өргөгчийн
----	---	---

**Гурав. Хүчингүй болгох ажил мэргэжил /17/**

- 2142-13 Инженер, бүтээц байгууламжийн
- 2142-19 Инженер, барилга угсралтын
- 2142-23 Инженер, ариутгах татуургын
- 2142-27 Инженер, хөгжлийн бэрхшээлтэй иргэний барилга байгууламжийн
- 2142-33 Инженер, ариутгах татуургын
- 2142-34 Инженер хотын байгууламжийн
- 2142-35 Хөдөө аж ахуйн, цамхагт байгууламжийн
- 2142-36 Инженер өрмийн сантехникийн
- 2142-37 Инженер зүтгүүрийн / төмөр замын, нисэх онгоцны
- 2142-38 Инженер тээврийн / агаарын, шумбагч онгоцны
- 2142-39 Инженер тийрэлтэт хөдөлгүүрийн
- 2142-40 Инженер усжуулалтын
- 2142-49 Инженер, барилгын усан хангамжийн
- 2142-50 Инженер, ариутгах татуургын
- 2144-38 Механикч инженер, үйлдвэрийн машины тоног төхөөрөмжийн
- 2144-39 Механикч инженер, салхивчийн
- 7212-20 Гагнуурчин, цахилгаан-хийн

-----oOo-----



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
2022 оны <sup>12</sup>дугаар сарын <sup>28</sup>ны өдрийн  
А/А/О дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН МЭДЭЭЛЭЛ

### Нэг. Шинээр нэмэгдсэн ажил, мэргэжил

#### 1121-50 Газар, хэлтсийн дэд захирал /дэд дарга, орлогч дарга/

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Department /Division/ deputy manager

Ажлын байрны тодорхойлолт: Газар, хэлтсийн дэд захирал /менежер/ нь компанийн тодорхой газар эсхүл хэлтсийн үйл ажиллагааг удирдах, зохицуулах, үр дүнг газар, хэлтсийн даргын өмнө хариуцан тайлагнана. Байгууллагын бодлого, зорилтод хүрэхийн тулд ажилтнуудыг удирдлага, зохицуулалтар хангана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Хэлтсийн дэд менежер
- Бизнесийн нэгжийн зохицуулагч
- Хэлтсийн дэд зохицуулагч
- Нэгжийн дэд захирал
- Бизнесийн нэгжийн дэд менежер

#### 1213-14 Эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчны дарга, эрхлэгч /менежер/

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Health, safety and environmental manager

Ажлын байрны тодорхойлолт: Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны менежерүүд хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалахтай холбоотой компанийн бодлого, журмыг боловсруулж, хэрэгжүүлнэ. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон байгаль орчны хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд бизнесийн үйл явцад дүн шинжилгээ хийх, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын чиглэлээр эрсдэлийн үнэлгээ хийх, эдийн засгийн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, ажлын орчин, соёлыг сайжруулахад чиглэсэн зохих арга хэмжээг боловсруулна. Эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг зохицуулж, үр дүнтэй үзүүлэлтүүдийг тодорхойлох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, мэдээлэх ажлыг хэрэгжүүлнэ. Байгууллагын болон салбарын менежерүүдтэй харилцаж, ажилтнуудыг сургах, бэлтгэх ажлыг хэрэгжүүлнэ. Эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой техникийн баримт бичгийн төслийг боловсруулах үүргийг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежер
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн газар, хэлтсийн дарга

**1219-17 Газар, хэлтсийн дарга, эрхлэгч /менежер/**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Department /Division/ manager

Ажлын байрны тодорхойлолт: Газар, хэлтсийн менежерүүд нь компанийн тодорхой газар, хэлтсийн үйл ажиллагааг хариуцна. Байгууллагын бодлого, зорилтод хүрэхийн тулд ажилтнуудыг удирдлага, зохицуулалтар хангана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Газрын дарга
- Хэлтсийн дарга
- Газар, хэлтсийн менежер
- Бизнесийн нэгжийн зохицуулагч

**1439-17 Хэрэглэгчдэд үйлчлэх, түгээх төвийн дарга /менежер/**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Customer service centre manager

Ажлын байрны тодорхойлолт: Хэрэглэгчдэд үйлчлэх, түгээх төвийн дарга /менежер/ нь хэрэглэгчдэд үйлчлэх, түгээх төвийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулж, төлөвлөнө. Хэрэглэгчдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгууллагын үйл ажиллагааны үр ашгийн нэмэгдүүлэх бодлого төлөвлөлтийг хийж хэрэгжүүлнэ. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг өндөр түвшинд хүргэхийн тулд ажилтнууд, нөөц боломж, үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

**2113- 51 Аналитик химич**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Analytical, chemist engineer

Ажлын байрны тодорхойлолт: Аналитик химич нь бодисын химийн найрлагыг судлах, тайлбарлах, төрөл бүрийн нөхцөлд бодисын шинж байдлаар дүгнэлт гаргана. Аналитик химичүүд хими ба хүрээлэн буй орчин, хоол хүнс, түлш, эм бэлдмэлийн хоорондын хамаарлыг судлахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэд цахилгаан хроматографи, хийн болон өндөр үзүүлэлттэй шингэний хроматографи, спектроскопи зэрэг олон төрлийн техникийг ашигладаг. Түүхий эд материал, нүүрс, туршилт тохируулгад хэрэглэх түүхий эдүүдэд химийн бүрэн шинжилгээ хийх, химийн шинжилгээний уусмал найруулж, тохируулж шалгах, тоног төхөөрөмж хэмжих хэрэгслүүдийг шалгаж хариуцах, тухайлсан материал, бүтээгдэхүүн, процессын химийн талаар судалж зөвлөгөө өгнө.

Ажил, мэргэжлийн жишээ.

- Инженер, петрографч
- Аналитик химийн шинжээч

**2114-33 Геохимич**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Geochemist

Ажлын байрны тодорхойлолт: Геохимичид ашигт малтмал, чулуулаг, хөрсний шинж чанар, химийн элементүүд, тэдгээрийн гидрологийн системтэй хэрхэн харилцан үйлчилж байгааг судална. Сорьц, дээж цуглуулах ажлыг зохицуулах, шинжилгээнд хамрагдах металлын бүрдлийг тодорхойлно.



Ажил, мэргэжлийн жишээ:

- Геотехникч
- Зөвлөх геохимич
- Газрын тосны техникч
- Геошинжлэх ухааны техникч
- Газрын тосны геохимич
- Хайгуулын геохимич
- Уул уурхайн геохимич
- Байгаль орчны геохимич
- Металлын шинжээч

**2141-49      Инженер, үйлдвэрлэлийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Plant engineer

Ажлын байрны тодорхойлолт: Технологийн шаардлага хангасан чанартай хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх жигд ажиллагааг техник технологийн горимын дагуу удирдан зохион байгуулна.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Ерөнхий эрчим зүйч, үйлдвэрлэлийн
- Горим болон тооцооны инженер

**2142-60      Инженер, барилга угсралтын мэдээлэл холбоо, дохиоллын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Construction information communication signal engineer

Ажлын байрны тодорхойлолт: Байгууллагын нэгдсэн дотоод, гадаад сүлжээ, цахим хуудас, мэйл хаяг, камерын хяналтын систем, цаг бүртгэлийн төхөөрөмж, сервер компьютерүүдийн хэвийн найдвартай, аюулгүй ажиллагааг хариуцаж ажиллах үүрэг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Инженер автоматжуулалтын

**2142-61      Инженер, барилгын материалын иж бүрэн автомат удирдлагатай технологийн шугамын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Building materials engineer in automatic controlled technological system

Ажлын байрны тодорхойлолт: Үйлдвэрийн технологийн горимын дагуу удирдан зохион байгуулж, технологийн шаардлага хангасан чанартай хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх найдвартай жигд ажиллагааг техник технологийн шаардлагын дагуу тасралтгүй жигд ханган, удирдан зохион байгуулна.

**2143-16      Мэргэжилтэн, дахин боловсруулалтын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Recycling specialist

Дахин боловсруулалтын мэргэжилтэн нь дахин боловсруулалтын бодлого, хууль тогтоомжийг судлана. Байгууллагын хог хаягдлын менежмент нь холбогдох бодлого, хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байгаад хяналт тавина. Хяналт шалгалт хийх, дахин боловсруулах тоног төхөөрөмжөөр хангах, дахин боловсруулалтын ажилчдыг ахлана. Байгууллагуудад хог хаягдлын менежментээ сайжруулах арга замын талаар зөвлөгөө өгнө.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Дахин боловсруулах, хог хаягдлыг бууруулах мэргэжилтэн
- Олон нийтийн дахин боловсруулалтын зохицуулагч
- Худалдааны төвийн дахин боловсруулалтын зохицуулагч
- Дахин боловсруулах багийн ахлагч
- Хог хаягдлыг дахин боловсруулах зохицуулагч
- Дахин боловсруулах бодлогын мэргэжилтэн

#### **2142-17      Хаягдал боловсруулах технологийн инженер**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Waste processing technological engineer

Ажлын байрны тодорхойлолт: Хаягдал боловсруулах технологийн инженерүүд нь хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, тараахад ашигладаг үйл явц, байгууламж, тоног төхөөрөмжийн зураг төслийг боловсруулна. Боловсруулсан хог хаягдлыг шинжлэх, ангилж замаар хог хаягдлыг боловсруулах журмыг оновчтой болгох, байгаль орчинд үзүүлэх хамгийн бага нөлөөллийг хангах үүднээс байгаль орчны стандарт, бодлогыг судална.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Хог хаягдал боловсруулах технологийн инженерийн зөвлөх
- Үйлдвэрийн хог хаягдал боловсруулах инженер
- Хог хаягдал боловсруулах инженерийн зөвлөх
- Хог хаягдал боловсруулах инженер
- Хаягдал боловсруулах технологийн инженер мэргэжилтэн

#### **2149-17      Инженер, эрүүл мэнд, аюулгүй байдлын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Health and safety engineer

Ажлын байрны тодорхойлолт: Эрүүл мэнд, аюулгүй байдлын инженерүүд нь инженерийн зарчим, эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагыг хослуулан ажиллана. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ажиллагчдыг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаргахаас урьдчилан сэргийлэхэд ажилчдын ажлын байран дахь хөдөлмөрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, нийт ажилчдад зааварчилгаа өгнө. Аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах арга хэмжээг төлөвлөнө.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Эрүүл ахуй, аюулгүй байдлын инженер
- Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын инженер
- Үйлдвэрлэлийн эрүүл ахуй, аюулгүй байдлын инженер
- Аюулгүй байдлын шинжээч
- Байгаль орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын инженер



**2152-32**

**Инженер, барилгын материал үйлдвэрлэлийн автоматжуулалтын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Automation of engineering and construction materials production

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын инженерийн системийн автоматжуулалт, үйлдвэрийн суурилагдсан тогтмол гүйдлийн агрегат, давтамжийн хувиргуурууд автомат удирдлагын системийн электрон, тоног төхөөрөмжийн угсралт болон өдөр тутмын үзлэг үйлчилгээ, засварыг хийж, найдвартай жигд ажиллагааг хангаж, үйлдвэрлэлийг тасралтгүй, жигд явуулахад засварчдын ажлыг чиглүүлэн удирдан зохион байгуулна. Алсын удирдлагатай автомат тоног төхөөрөмжийг технологийн шаардлагын дагуу тасралтгүй, жигд найдвартай ажиллаж байх нөхцлийг хангахын тулд автомат тоног төхөөрөмж, техник хангамж, програм хангамж, дотоод сүлжээ, технологийн хяналтын камерыг хэвийн ажиллуулах, шинээр туршин нэвтрүүлэх, хөгжүүлэх ажлыг хариуцаж буй инженерийн хамт хэрэгжүүлнэ.

**2161-14**

**Интерьер архитекторч /дизайнер/**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Interior architect

Ажлын байрны тодорхойлолт: Интерьер архитекторчид байшин, барилга эсвэл бусад байгууламжийн дотоод засал чимэглэлийн төлөвлөгөөг гаргана. Орон зайн нарийвчлал, хуваарилалтыг тодорхойлно. Зохистой интерьер дизайн гаргахын тулд орон зайн талаархи ойлголтыг гоо зүйн мэдрэмжтэй хослуулдаг. Архитектурын зураглалыг компьютерийн төхөөрөмж, программ хангамж, эсвэл цаас, үзэг гэх мэт уламжлалт аргуудыг ашиглан зурна.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Архитекторч
- Орон зайн төлөвлөлтийн интерьер дизайнер
- Барилгын дизайнер
- Дотоод засалч

**2165-27**

**Зураг зүйч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Cartographer

Ажлын байрны тодорхойлолт: Газрын зураг зүйчид газрын зургийн зорилгоос (жишээ нь байр зүйн, хотын, улс төрийн г.м. газрын зураг) хамааран янз бүрийн шинжлэх ухааны мэдээллийг нэгтгэн газрын зургийг бүтээнэ. Зураг зүйч нь дэлхийн хэлбэр, хэмжээ, түүний хүндийн хүчний таталцлын талбарыг тодорхойлох, газрын гадаргуугийн цэг, орон зайн биетийн солбицол, өндөр, хүндийн хүчний хурдатгалыг тодорхойлох, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн газрын зураг зохиох, шинэчлэх, дэлхийн царцдасын хэвтээ, босоо хөдөлгөөний өөрчлөлтийг судлана. Геодези, зураг зүй, геоматик, газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын мэдлэгээ нийгэм, эдийн засгийн бүх салбарт хэрэглэнэ. Газар зүйн мэдээллийн системийг хөгжүүлэх, сайжруулах чиглэлээр ажиллаж, зураг зүйн чиглэлээр шинжлэх ухааны судалгаа хийж болно.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Газрын зураг бүтээгч
- Зураг зүйн шинжээч
- Зураг зүйн судлаач

## **2165-28 Газар зүйн мэдээллийн системийн мэргэжилтэн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Geographic information systems specialist

Ажлын байрны тодорхойлолт: Газар зүйн мэдээллийн системийн мэргэжилтнүүд газар, газарзүйн болон орон зайн мэдээллийг боловсруулахдаа тусгай компьютерийн систем, инженерийн арга хэрэгсэл, геологийн ухагдахууныг ашиглан дижитал газрын зураг, геомоделийг дүрслэн харуулдаг. Хөрсний нягтрал, шинж чанар зэрэг техникийн мэдээллийг сонирхогч тал, төрийн байгууллага, инженерүүдэд дижитал дүрслэл болгон хувиргана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Газарзүйн мэдээллийн систем /ГМС/-ийн зөвлөх
- ГМС зураглалын техникч
- ГМС программын мэргэжилтэн
- ГМС-ийн шинжээч
- ГМС-ийн техникч
- Дэлхийг ажиглах мэргэжилтэн

## **2413-14 Санхүүгийн шинжээч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Financial analyst

Ажлын байрны тодорхойлолт: Санхүүгийн шинжээч нь эдийн засгийн судалгаа хийж, ашигт ажиллагаа, хөрвөх чадвар, төлбөрийн чадвар, хөрөнгийн удирдлага зэрэг санхүүгийн асуудлаар дүн шинжилгээ хийнэ. Шийдвэр гаргах үйл явцад санхүүгийн асуудлаар зөвлөмж өгнө. Төр, хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нөлөөлж байгаа мэдээлэлд тоон дүн шинжилгээ хийнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Төсөв үнэ бүрдлийн шинжээч
- Санхүүгийн зах зээлийн шинжээч
- Хөрөнгийн зах зээлийн шинжээч
- Эдийн засгийн шинжээч
- Банкны шинжээч
- Зээлийн шинжээч
- Санхүүгийн судлаач

## **2413-15 Хөрөнгө оруулалтын шинжээч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Investment analyst

Ажлын байрны тодорхойлолт: Хөрөнгө оруулалтын шинжээчид сангийн менежерүүдэд зохих зөвлөмж өгөхийн тулд судалгаа хийнэ. Хөрөнгө оруулалтын талаар дэлхийн хэмжээнд судалгаа хийдэг ч ажил олгогчийн онцлог, үйл ажиллагааны чиглэлээс хамааран жижиглэн худалдаа, дэд бүтэц, эрчим хүч, банк санхүү, санхүүгийн үйлчилгээ зэрэг салбарт мэргэших боломжтой. Санхүүгийн зах зээлд нөлөөлж болох улс төр, эдийн засгийн хөгжил, зорилтот компаниудын санхүүгийн гүйцэтгэл зэрэг санхүү, эдийн засгийн мэдээллийг анхаарч, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хэрхэн нөлөөлж байгааг ойлгохын тулд янз бүрийн эх сурвалжаас авсан мэдээллийн боловсруулалтыг ашиглана.



Ажил, мэргэжлийн жишээ:

- Хөрөнгө оруулалтын тооцооллын шинжээч
- Хөрөнгө оруулалтын банкны шинжээч
- Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн
- Газрын тос, байгалийн хийн хөрөнгө оруулалтын банкны шинжээч
- Хөрөнгө оруулалтын ажилтан

**3112-38      Техникч, гүүр, тунелийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Bridge, tunnel technician

Ажлын байрны тодорхойлолт: Гүүр, тунелийн холбоосын эвдрэл, цууралт, зэврэлт болон бусад гэмтлийг шалгана. Гүүр, тунелийн байгууламжийн засвар үйлчилгээ хийх буюу зохион байгуулах ажлыг хариуцна.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Гүүрний байцаагч
- Гүүр, байгууламжийн байцаагч
- Хурдны замын байгууламжийн байцаагч

**3132-13      Операторч/Машинч, бохир усны насос станцын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Wastewater treatment operator

Ажлын байрны тодорхойлолт: Бохир ус хүлээн авч дамжуулан шахах болон өргөлтийн насос тоног төхөөрөмжийн үзлэг үйлчилгээг тогтмол хийх, горимын дагуу ажиллуулах, хэвийн ажиллагааг хянах, тэмдэглэл хөтлөх ажлыг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Бохир ус, ариутгах татуургын насос станцын машинч, операторч
- Операторч/ Машинч, бохир усны насос станцын
- Операторч/Машинч, сараалжийн
- Операторч/Машинч, бохир усны өргөлтийн насос станцын

**3132-15      Техникч/Механикч, ус цэвэршүүлэх үйлдвэр, станцын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Technician/mechanic, water treatment plant and station

Ажлын байрны тодорхойлолт: Цэвэр усыг шахах, түгээх насос, тоног төхөөрөмжийг үзлэг үйлчилгээг тогтмол хийх, горимын дагуу ажиллуулах, хэвийн ажиллагааг хянах, цаг тутам насосны ажиллагааны тэмдэглэл хөтлөх ажлыг гүйцэтгэнэ. Ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх, хлорын ашиглалтад хяналт тавих, хлорт төхөөрөмжийн тасралтгүй ажиллагааг хангана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Хлорт тоног төхөөрөмжийн операторч
- Ус шахуургын станцын техникч/механикч
- Ус цэвэршүүлэх төхөөрөмжийн техникч/механикч

**3313-16      Нягтлан бодох бүртгэлийн туслах**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Accounting assistant

Ажлын байрны тодорхойлолт: Нягтлан бодох бүртгэлийн туслах нь нягтлан бодох бүртгэлийн нөхцөл байдлыг хамтран ажилладаг нягтлан бодогчид бүртгэж, тайлагнаж, хадгаламжийг баталгаажуулж, өдөр тутмын орлого, тайлан, бэлтгэнэ. Буцаан олголтын эрхийн бичгийг зохион байгуулах, буцаасан мөнгөний баримтын дансыг хөтлөх, тасалбарын системтэй холбоотой аливаа асуудлын талаар тасалбарын менежерүүдтэй харилцана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Туслах нягтлан бодогч
- Нягтлан бодогчийн туслах
- Нягтлан бодох бүртгэлийн туслах
- Тооцоо, бүртгэлийн туслах
- Санхүүгийн туслах

**5245-13      Ус түгээгч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Water distributor

Ажлын байрны тодорхойлолт: Гэр хорооллын хүн амд эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдал хангасан цэвэр усыг түгээх үйлчилгээг хүргэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Зөөврийн ус түгээх байрны түгээгч
- Шугамын ус түгээх байрны түгээгч
- Ухаалаг ус түгээх байрны түгээгч
- Дундын түгээгч
- Усны машинаар ус түгээгч

**7112-19      Өрөгч, угсрагч, барилгын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Layer and assembler of construction

Ажлын байрны тодорхойлолт: Өрөгч, угсрагч, холбогдох бусад ажилтан нь тоосго, урьдчилан зүсч бэлтгэсэн чулуу, бусад төрлийн барилгын гулдмайгаар өргийн зуурмаг ашиглан хана, хамар хана болон бусад бүтээцийг өрөх, угсрах, засварлах ажлыг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Зуухны өрөгч, зуух, хатаагуурын тэргэнцэрт өрөгч, хатаах талбай, бэлэн бүтээгдэхүүн улавчинд өрөгч
- Доторлогоочин, барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн төрлийн зуух, хатаагуур, хөргөгч, дулаан солилцуулагчийн

**7112-23      Барилгын хэв хашмал угсрагч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Mold assembler for fabricated construction



Ажлын байрны тодорхойлолт: Угсармал том, жижиг самбартай хэв, хашмал, түүний бэхэлгээ, тулаасыг угсрах ажлыг гүйцэтгэнэ. Тухайлбал өрөө тусгаарлах хана болон хаалга цонхыг хэвэн дээрээ байршуулж цутгах, хучилтын хавтан угсрах, бэхлэх, төмөр татанги /ферм/ дам нуруу угсрах, бэхлэх зэрэг.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Гадна дүүргэлтийн хана угсрагч
- Фасадны шилэн хийц угсрагч
- Гадна ханыг дулаалагч
- Гадна ханын өнгөлгөө хийх
- Тусгаарлах хана угсрагч
- Ган болон төмөр бетон бүтээцийн угсрагч
- Гадна ханын өнгөлгөөчин

### **7113-10 Чулуучин**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Stonemason

Ажлын байрны тодорхойлолт: Чулуучин нь хатуу болон зөөлөн чулуун гулдмайг зүсч, хэлбэржүүлэн өнгөлөхөөс гадна барилгын чулуун бүтээц, чимэглэлийн өрөгийг гүйцэтгэх, арчилах ба чулуун дээрх сийлбэрийн загварыг гарган, гүйцэтгэх ажлыг хийнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Байгалийн чулуун эзлэхүүн бэлтгэгч
- Барилгын фасадны чулуун плитачин
- Чулууны өнгөлгөөний машины операторч
- Чулуун бродюр, хавтан зүсэгч машины операторч

### **7119-23 Барилгын буулгалт /нураалт/-ын ажилтан**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Demolition worker

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын буулгалт /нураалт/-ын ажилчид барилга байгууламжийг нураах тоног төхөөрөмжөөр ажилладаг. Барилга байгууламжийг аюулгүйгээр нурааж, хог хаягдлыг зайлуулж, талбайг өөр зориулалтаар ашиглах нөхцөлийг хангана..

Ажил, мэргэжлийн жишээ:

- Нураалтын ажилтан
- Нураалт, буулгалтын ажилтан

### **7122- 21 Хулдаас, чулуу, плитагаар шаллагч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Tile, stone and tile flooring

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын гадна талбай болон явган хүний гудамжны хатуу болон зөөлөн чулуун гулдмайг зүсч, хэлбэржүүлэн өнгөлөх, барилгын чулуун бүтээц, чимэглэлийн өрөгийг гүйцэтгэх, арчилах, загварыг гарган гүйцэтгэх ажлыг хийнэ.

**7123-20 Тааз суурилуулагч, угсрагч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Ceiling installer and assembler

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын тааз суурилуулах ажлыг гүйцэтгэнэ. Тааз суурилуулахдаа тусгаарлалтын гадаргууг цэвэрлэх, барилгын зураг төслийн дагуу болон захилагчаас өгсөн саналын дагуу нөхцөл байдалд нийцүүлэн төрөл бүрийн арга техник ашиглана. Тухайлбал галд тэсвэрлэх чадвар, уналттай тааз болон дараагийн давхрын хоорондын зай зэрэг.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Үйлдвэрийн тааз суурилуулагч
- Дүүжин тааз суурилуулах
- Тааз суурилуулагч

**7213-10 Нимгэн төмөрчин**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Thin metal workers

Ажлын байрны тодорхойлолт: Нимгэн төмөр ашиглан дээвэр, халаалт, агааржуулалт, агааржуулалтын суваг, хоолой болон бусад метал байгууламжийг барина. Нимгэн төмрийг зүсэх, хэлбэр гаргахаар зурж тэмдэглэх, тугалга, зэс, бусад зөөлөн хайлшаар ахуйн хэрэглээний ба гоёл чимэглэлийн зүйлс хийж, засна.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Нимгэн төмөрчин, эсгүүрчин /Агааржуулалтын хоолойн/

**7411-13 Цахилгаан хөдөлгүүр задлагч, ороогч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Electric engine unwinder and winder

Ажлын байрны тодорхойлолт: Үйлдвэрийн цахилгаан хөдөлгүүрийн найдвартай үйл ажиллагааг хангаж, яаралтай засварлаж, үйлдвэрлэлийн хэвийн жигд ажиллагааг хангана. Цахилгаан, механик (хагас механик) болон цахим төхөөрөмжийн эд анги, хэсгүүдийг нарийн чанд дагаж мөрдөх ажилбарын дагуу угсрах, өөрчлөх, сайжруулах зэрэг ажил эрхэлнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Цахилгаан төхөөрөмж угсрагч
- Цахилгаан төхөөрөмж засварлагч

**8114-23 Операторч, эргэх зуух, тээрмийн, хөргөх төхөөрөмжийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Operator, rotary kiln, mill, cooling equipment

Ажлын байрны тодорхойлолт: Эргэх зуухны үндсэн тоног төхөөрөмж болон туслах тоног төхөөрөмжийг хариуцан ажиллана. Эргэх зуухны корпус, венец, подвенец араа, тулгуур булнууд ба зуухны өгсөлт уруудалт, тосны өгөлтийн даралтыг тогтмол хянаж, тулгуур булны холхивч тослож байгаа эсэхийг хянан, шаардлагатай үед нэмнэ. Эргэх зуухны корпус болон булнуудын халалтуудыг тогтмол шалгаж хүйтэн агаарын вентиляторуудыг хэвийн ажиллуулна. Үйлдвэрлэлийн явцад шохойн зуухны технологийн жигд ажиллагааг найдвартай хангаж ажиллах, гэмтэл гарсан үед түргэн шуурхай арга хэмжээ авч тасралтгүй үйл ажиллагааг хангах, стандартын



шаардлага хангасан шохой үйлдвэрлэнэ. Тээрмийн үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүдийг хэвийн жигд найдвартай ажиллуулах, технологийн шаардлагад нийцсэн түлш түүхий эдийг нунтаглан хатаах, цемент, бусад эрдэс бүтээгдэхүүн үйлдвэрлэх машин механизмыг ажиллуулах, буталж ангилсан чулуу, нэмэлт түүхий эд, гөлтгөнөөр тасралтгүй ханган үйлдвэрлэлийн жигд ажиллагаа, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангана. Хөргөгч болон цахилгаан филтерийн туслах тоног төхөөрөмжүүдийг хэвийн жигд найдвартай ажиллуулж, урьдчилан халаагчтай зуухнаас гарсан халуун материалыг хөргөх ажлыг гүйцэтгэнэ.

**8114-24 Барилгын материалын үйлдвэрийн дамжлагын операторч /чулуунцарын/**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Operator of all process of construction materials industry

Ажлын байрны тодорхойлолт: Шохойн чулуу, эрдэс бүтээгдэхүүний түүхий эдийг татаж үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ачаалах төхөөрөмжийн хэвийн жигд ажиллагааг хангаж, үйлдвэрлэлийн явцад технологийн жигд ажиллагааг найдвартай хангаж ажиллах, гэмтэл гарсан үед түргэн шуурхай мэдэгдэх, зохих шаардлагын дагуу тасралтгүй үйл ажиллагааг хангана. Хэмжих хэрэгслийн жигд ажиллагааг хангаж, түлш, түүхий эдийг туузан дамжлагаар зөөвөрлөн, технологийн жигд ажиллагааг хангана. Урьдчилсан халаагч болон туслах тоног төхөөрөмжүүдийг хэвийн жигд найдвартай ажиллуулна. Эргэх зуухны урьдчилан халаагчийн жигд ажиллагаанд тогтмол хяналт тавьж, чанартай чулуунцар үйлдвэрлэх, урьдчилан халаагчтай эргэх зуухнаас гарсан чулуунцарыг нэгдсэн склад руу зөөвөрлөнө.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Чулуунцарын дамжлагын операторч

**8142-23 Хуванцар хоолойн машины операторч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Plastic pipe machine operator

Ажлын байрны тодорхойлолт: Хуванцар холимогийг орц, нормын дагуу бэлдэх, холих, зуурах болон төрөл бүрийн хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэх машиныг ажиллуулах, хянах ажлыг гүйцэтгэнэ. Төрөл бүрийн түүхий эдээр хуванцар хоолой үйлдвэрлэх шугамыг мэргэжлийн түвшинд ажиллуулна.

Ажил мэргэжлийн жишээ:

- Хуванцар хоолойн түүхий эдийн найруулга тохируулагч
- Хуванцар хоолой бэлтгэх машины операторч

**8332-20 Жолооч, ариутгах татуургын машины**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Sewerage machine driver

Ажлын байрны тодорхойлолт: Захиалгын дагуу ариутгах татуургын машин механизмаар үйлчилж, бохирын худгийн бөглөрлийг гаргана. Хэрэглэгчдээс бохир усыг татан зайлуулахтай холбоотой өгсөн захиалга, дуудлагын дагуу ариутгах татуургын шугам, сүлжээнд гарсан гэмтэл саатлыг арилгах үйлчилгээг үзүүлнэ.

**8332-21      Операторч, тусгай тоноглол бүхий машины**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Special equipment vehicle operator

Ажлын байрны тодорхойлолт: Байгууллагын болон тоног төхөөрөмж бүхий төв пунктууд (ус, дулаан дамжуулах төвүүд гэх мэт)-ийн цахилгаан удаан хугацаагаар тасарсан үед цахилгаанаар хангаж, хэрэглэгчдийг түр хугацаанд ус, дулаанаар таслахгүй байх, захиалгаар ажиллахад машин техникээ бэлэн байлган, аюулгүй байдлыг хангана. Инженерийн шугам сүлжээний засварын ажлыг хийхэд шаардлагатай тусгай тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлнэ.

Гал түймрийн албаны тээврийн хэрэгслийн жолоочид энэ ангилалд хамаарна. Гал түймэр яаралтай унтраах үйлчилгээний машиныг жолоодож, ажиллуулна. Яаралтай жолоодлогын чиглэлээр мэргэшсэн байх бөгөөд гал түймэртэй тэмцэх ажилд тусална.

Ажил мэргэжлийн жишээ:

- Гал түймрийн албаны тээврийн хэрэгслийн оператор

**8342- 28      Операторч, скреперын /хусагчийн/**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Scraper operator

Ажлын байрны тодорхойлолт: Скреперийн операторууд хөдөлгөөнт хүнд тоног төхөөрөмжтэй ажиллаж газрын дээд давхаргыг хусаж, зөөвөрлөх зорилгоор саванд /ёроолоор гадагшлуулах боломжтой/ хадгална. Хусах гадаргуу дээгүүр хусагчийг жолоодож, машины хурдыг гадаргуугийн хатуулагт тохируулна.

Ажил мэргэжлийн жишээ:

- Хусагчийн жолооч
- Хүнд үйлдвэрийн оператор, хусагч
- Чирэх хусуурын оператор
- Скреперын машинчин

**9313-14 Барилгын газар, шуудууны ажилтан, нүх ухагч нягтруулагч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Construction site, ditch worker, hole digger and compactor

Ажлын байрны тодорхойлолт: Механизмээр ухагдсан суурийн суваг, хүнхээл, шуудууг гараар засаж ухах, хөрсний төрөл шинж чанараас хамааран эргийн налуу гаргах, бэхэлгээ хийх, хөрс бэхлэх, ус соруулах, суурь бэлтгэх, барилгын суурь, зоорь, шугам сүлжээ тавигдсан шуудуу зэргийг эргүүлж булах, нягтруулах, түүнчлэн гүүр, авто зам, нисэх онгоцны хөөрөх буух зурвасыг ухах, нягтруулах ажлыг хийнэ.

**Хоёр. Нэршилд өөрчлөлт орсон ажил, мэргэжил**

**1212-13      Дарга, эрхлэгч /менежер/, хүний нөөцийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Human resources manager

Ажлын байрны тодорхойлолт: Хүний нөөцийн менежерүүд хүний нөөцтэй холбоотой үйл явцыг төлөвлөж, хэрэгжүүлнэ. Байгууллагад шаардлагатай ур чадвар, өмнөх үнэлгээнд үндэслэн



ажилтан элсүүлэх, ярилцлага хийх, сонгох хөтөлбөр боловсруулна. Түүнчлэн ажилтнуудад зориулсан сургалт, ур чадварын үнэлгээ, жилийн үнэлгээ, албан тушаал ахих, гадаадад ажиллах хөтөлбөрүүд, ажилчдын ажлын байран дахь сайн сайхан байдлын ерөнхий баталгаа зэрэг ажилтнуудад зориулсан нөхөн төлбөр, хөгжлийн хөтөлбөрийг удирдана.

Ажил мэргэжлийн жишээ:

- Ажилтан элсүүлэх, сонгох албаны дарга
- Хүний нөөцийн захирал
- Боловсон хүчний менежер

**1324-11 Дарга, эрхлэгч /менежер/, логистик, түгээлтийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Logistics and distribution manager

Ажлын байрны тодорхойлолт: Логистик, түгээлтийн менежерүүд логистикийн үйлчилгээ, үйл ажиллагаа, хангамжийн талаар шийдвэр гаргана. Байгууллагын логистикийн үйлчилгээг үр дүнтэй, амжилттай явуулахын тулд дотоод болон гадаад хүчин зүйлсийг харгалзана. Нийлүүлэлтийн сүлжээний бүх үйл ажиллагаанд эхнээс нь дуустал зохих дэмжлэг үзүүлнэ. Барааг хадгалах, түгээх ажлыг зохион байгуулж, зөв бүтээгдэхүүнийг зөв газарт цаг тухайд нь, боломжийн үнээр хүргэх ажлыг хангана.

Ажил мэргэжлийн жишээ:

- Логистикийн менежер
- Логистик, түгээлтийн захирал
- Логистикийн зохицуулагч
- Нийлүүлэлтийн сүлжээ логистикийн менежер

**1324-13 Дарга, эрхлэгч /менежер/, хангамжийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Supply manager

Ажлын байрны тодорхойлолт: Хангамжийн менежерүүд түүхий эдийг олж авахаас эхлээд эцсийн бүтээгдэхүүн түгээх хүртэлх үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хангамжийн эх үүсвэр, худалдан авалттай холбоотой бүх үйл ажиллагааг төлөвлөж, удирдаж, зохицуулна. Хангамж нь түүхий эд эсхүл эцсийн бүтээгдэхүүн байж болох бөгөөд дотоодын болон гадаадын хэрэгцээнд зориулагдсан байж болно.

Ажил мэргэжлийн жишээ:

- Нийлүүлэлтийн сүлжээний менежер
- Хангамж, түгээлтийн менежер

**2114-15 Геологич инженер**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Geological engineer

Ажлын байрны тодорхойлолт: Геологийн инженерүүд газар нутаг, хөрс, налуугийн тогтвортой байдал, хурдас болон дэлхийн бусад ажиглагдах шинж чанарыг үнэлнэ. Хот суурин, дэд бүтцийн хүрээнд нутаг дэвсгэрийн газрын талбай, зурвасын геологи орчин, инженер-геологийн нөхцөлийг, зураг төсөл боловсруулахад шаардагдах инженер-геологийн үзүүлэлтүүдийг тогтоох, геологи

орчин, инженерчлэлийн нөхцөлийн цаашдын хувиралт, өөрчлөлтөд үнэлэлт өгнө. Хөрсний геологийн шинж чанартай холбоотой асуултуудыг үнэлж, хариулна.

Ажил мэргэжлийн жишээ:

- Геологийн технологийн инженер
- Геотехникийн инженер

#### **2142-11 Инженер, барилга байгууламжийн бүтээцийн технологийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Engineering and technology of building construction

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын бүтээц хийцийн ашиглалт болон технологийн доголдол, шинэчлэлийн асуудлыг шийдвэрлэнэ. Барилга угсралтад ирж байгаа зуурмагын найрлага нь технологийн дагуу ирж байгаад хяналт тавьж, хэвийн ажиллагааг хангана. Үйлдвэрлэлийг хөтлөн явуулах, технологи ба шаардлагад нь нийцүүлэн түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийх, технологийн туршилт явуулна.

#### **2142-16 Инженер, иргэний ба үйлдвэрийн барилгын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Civil and plant construction engineer

Ажлын байрны тодорхойлолт: Иргэний ба үйлдвэрийн барилгын дизайн шууд угсралтын талаар судалгаа хийх, зөвлөгөө өгөх, барилга байгууламжийн явц, засвар үйлчилгээг удирдах, тодорхой материал технологийн шинж чанарын асуудлаар судалгаа хийж, зөвлөгөө өгнө. Түүнчлэн барилга угсралтын ажлын менежмент болон техник-эдийн засгийн үндэслэл, тооцоог эрхлэн гүйцэтгэнэ.

#### **2142-17 Инженер, замын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Road engineer

Ажлын байрны тодорхойлолт: Зам, гүүрийн барилгын зураг төсөл боловсруулна. Замын ажил удирдан гүйцэтгэж, чанарын хяналт тавих, замын материалын чанарын хяналт хийх, ашиглагдаж буй замын техник ашиглалтын түвшинг судлана.

#### **2142-31 Инженер, гүүр, тунелийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Bridge and tunnel engineer

Ажлын байрны тодорхойлолт: Гүүр, барилга байгууламж төлөвлөн, замын хөдөлгөөний урсгалд дүн шинжилгээ хийнэ. Гадна хөрс, материалын туршилт, судалгаа, тооцоо, төлөвлөгөө, тодорхойлолт, компьютерийн суурь мэдлэг, гидрологи, хурдны замын зураг төслийн дагуу гүйцэтгэнэ. Гүүр, хиймэл байгууламжийн засварын ажлыг гүйцэтгэхэд захиалагчийн хяналт тавих, үзлэг шалгалт хийх, арчлалт, хамгаалалтын ажлыг зохион байгуулна. Гэнэтийн болон байгалийн гамшгийн улмаас авто зам, замын байгууламжид гарсан эвдрэл, гэмтлийг засварлана.

#### **2142-32 Инженер, ус хангамж, ариутгах татуургын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Water supply and sanitation engineer



Ажлын байрны тодорхойлолт: Усны нөөц баялгийг зөв зохистой ашиглах, нөөцөд үнэлгээ өгөх, усыг цэвэрлэн цэнгэгжүүлэх, уснаас учруулж болох хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, ахуйн болон үйлдвэрийн бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх, дахин болон давтан эргүүлэн ашиглах зэрэг ус хангамж, бохир ус цэвэрлэгээний ажлыг удирдах, ажлыг хариуцаж ажиллана. Барилгын гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, байгууламж, дотор цэвэр бохир усны зураг төсөл, тооцоо хийх, угсралтын ажлыг удирдана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Орон сууц, нийтийн аж ахуйн инженер

**2142-41 Инженер, усны барилга байгууламжийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Hydro construction engineer

Ажлын байрны тодорхойлолт: Далан, суваг, үерийн усны систем, шугам хоолой, усан цахилгаан станцын зураг төсөл, тооцоо хийн, тэдгээрийн барилга угсралтын ажлыг удирдан, ашиглалтыг хариуцаж ажиллана. Усны барилга байгууламжийн үйлдвэрлэлийг удирдан, барилгын ба усны ашиглалтад мэргэжлийн хяналт тавина.

**2142-44 Инженер, цэвэрлэх байгууламжийн технологич**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Treatment plant technologist engineer

Ажлын байрны тодорхойлолт: Цэвэрлэх байгууламжийн өдөр тутмын үйл ажиллагааг технологийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан зохих технологийн горим тогтоож, хэрэгжүүлж ажиллана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Ус хангамж, ариутгах татуургын инженер

**2142-48 Барилгын материал үйлдвэрлэлийн технологич инженер**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Technological engineer of construction material production

Ажлын байрны тодорхойлолт: Түүхий эдийн нөөцөд түшиглэн барилгын материал, бүтээц эдлэл үйлдвэрлэх, түүнд орох материалын зохистой найрлагын тооцоог хийх, механик болон дулаанаар боловсруулах технологийн зохистой горим тогтоох зэрэг техникийн болон чанарын хяналтыг хэрэгжүүлнэ.

**2142-52 Инженер, халаалт, агаар сэлгэлт, агааржуулалтын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Heating, ventilation, air conditioning engineer

Ажлын байрны тодорхойлолт: Халаалт, агаар сэлгэлт, агааржуулалтын инженерүүд нь орон сууц, үйлдвэр, албан байгууллага, худалдаа зэрэг барилга, байгууламжийн ашиглалтад зориулж халаалт, агаар сэлгэлт, агааржуулалтын мөн шаардлагатай бол хөргөлтийн системийг зохион бүтээж, хөгжүүлнэ. Барилгын гадна дулааны сүлжээ, байгууламж, дотор халаалт, агаар сэлгэлт, хөргөлт, хий хангамжийн системийн зураг төсөл, тооцоо хийх, угсралт, тохируулгын ажлыг удирдах, ашиглалтыг хариуцаж ажиллана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Халаалт, агаар сэлгэлт, агааржуулалт, хөргөлтийн инженер
- Агааржуулалтын инженер
- Агаар сэлгэлтийн инженер
- Хөргөлтийн инженер

**2146-22 Инженер, маркшейдер**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Engineer surveyor

Ажлын байрны тодорхойлолт: Уурхайг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажлыг зураглалаар чиглүүлэх, уулын ажлын тасралтгүй жигд ажиллагааг хэвийн явуулах, ойрын болон хэтийн төлөвт чиглэсэн маркшейдерын мэргэжлийн удирдлагаар хангана. Хууль тогтоомж, удирдлагын шаардлагын дагуу уул уурхайн төлөвлөгөөг боловсруулж, хөтөлнө. Уул уурхайн үйл ажиллагаа, хүдэр эсвэл ашигт малтмалын үйлдвэрлэлийн биет явцын бүртгэлийг хөтөлнө.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Уурхайн маркшейдер
- Уурхайн төлөвлөлтийн маркшейдер

**2411-12 Нягтлан бодогч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Accountant

Ажлын байрны тодорхойлолт: Нягтлан бодогчид санхүүгийн тооцоо, төсөв, санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөөг хянаж, дүн шинжилгээ хийн, алдаа, залилангаас үүссэн зөрчлийг шалгаж, санхүүгийн таамаглал, эрсдэлийн шинжилгээ зэрэг асуудлаар санхүүгийн зөвлөгөө өгнө. Санхүүгийн мэдээлэлд аудит хийх, татварын тайлан гаргах, хууль тогтоомжийн дагуу татвартай холбоотой зөвлөгөө өгөх боломжтой.

**3112-11 Техникч, иргэний ба үйлдвэрийн барилга байгууламжийн**

Ажил, мэргэжлийн нэр /англиар/: Civil and industrial construction technician

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд тусална. Тухайлбал барилгын төлөвлөлт, хяналт, барилгын ажилд тендер зарлах, нэхэмжлэх зэрэг зохион байгуулалтын ажлыг хариуцна. Түүнчлэн материалын хэрэгцээг тооцоолж, барилгын материалын чанарыг ханган худалдан авахад тусална. Иргэний ба үйлдвэрийн барилга байгууламжийн техникч нь барилгын инженерийн чиглэлээр техникийн чиг үүрэг гүйцэтгэж, авто замын ажил, гэрлэн дохио, ариутгах татуурга, усны менежментийн тогтолцооны бодлого хэрэгжүүлэх стратегийг боловсруулж, зөвлөгөө өгөх боломжтой.

**3112-12 Техникч/механикч халаалт, агаар сэлгэлтийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Heating and ventilation equipment technician

Ажлын байрны тодорхойлолт: Агааржуулалтын болон агаар сэлгэлтийн систем, түүний тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, засварлах, ашиглалт үйлчилгээнд хяналт тавина.

Ажил, мэргэжлийн жишээ:



- Халаалтын тоног төхөөрөмжийн техникч/механикч
- Агаар сэлгэлтийн төхөөрөмжийн техникч/механикч

### **3112-13      Техникч, ус хангамж, ариутгах татуургын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Water systems engineering technician

Ажлын байрны тодорхойлолт: Усыг цэвэршүүлж, хот суурин газрын ус хангамжид нийлүүлэх үйлдвэр станц, ус, дулаан дамжуулах төвийн насос, тоног төхөөрөмжийн үзлэг үйлчилгээг тогтмол хийх, горимын дагуу ажиллуулах, хэвийн ажиллагааг хянах, тэмдэглэл хөтлөлтөд хяналт тавина. Шингэн хог хаягдал боловсруулах, ариутгах татуургын шугам хоолой, бохир ус цэвэрлэх байгууламж, насос, тоног төхөөрөмжийн үзлэг үйлчилгээг тогтмол хийх, горимын дагуу ажиллуулах, хэвийн ажиллагааг хянана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Ус хангамжийн шугамын техникч
- Бохир усны шугамын техникч
- Усны хэмжих хэрэгслийн техникч

### **3112-15      Техникч, хөрс, суурь судалгааны**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Soil and basic research technician

Ажлын байрны тодорхойлолт: Инженерийн геологийн ерөмдлөгийн ажлыг норм дүрмийн дагуу хийж, хөрсний дээжид боловсруулалт хийнэ. Хөрсний тогтоц, бүтцийн ширхэглэл, нуралтын өнцөг, хөрсний байгалийн хөлдөлтийн гүн, хөрсний усны түвшин, цэвдэгтэй эсэх гэх мэт үзүүлэлтүүдийг тогтоон газрын ажлыг ямар арга технологи баримтлан гүйцэтгэхийг тодорхойлно.

### **3112-22      Техникч, гидрогеологич**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Technician, hydrogeologist

Ажлын байрны тодорхойлолт: Гидрогеологичийн техникч нь байгаль орчны хэлтсийн усны багийн ажилд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, төслийн усны нөөцийг үнэлэх, тайлан мэдээ бэлтгэх, усны хяналт шинжилгээний хөтөлбөрийг удирдан зохион байгуулна. Гидрогеологийн хайгуул судалгааны үйл ажиллагаанд хяналт тавина.

### **3112-23      Техникч, байгууламжийн чанар, стандарт, хяналтын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Construction quality, standards and monitoring technician

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын чанар, стандарт, хяналтын техникчид томоохон барилгын үйл ажиллагаанд хяналт тавьж, стандарт, техникийн нөхцөлийн дагуу явагдаж байгаа эсэхийг хянана. Болзошгүй аюулаас сэргийлэхэд анхаарч, бүтээгдэхүүний сорьц, загварыг авч стандарт, техникийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Барилгын чанарын байцаагч
- Барилгын чанар, стандартын хянагч

- Барилгын чанар, аюулгүй байдлын хяналтын байцаагч

**3112-25      Техникч, барилга байгууламжийн хийцийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Construction structural technician

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын материал, хийцийн үйлдвэрлэл болон цемент, шохой, чулуунцарын үйлдвэрүүдэд чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нийлүүлэгдэж байгаа түлш, түүхий эд, материалын тоо хэмжээ, талбайн ашиглалт, ангилан ялгалт, чанарт хяналт тавьж, нэгтгэн дүгнэх, машин механизмын ашиглалтыг сайжруулах үүрэг гүйцэтгэнэ.

**3112-34      Техникч, төсөв, үнэ бүрдлийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Budget and cost estimation technician

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын үнэ бүрдэл төсөв, санхүүгийн тооцоо хийнэ. Шинээр барих, угсрах болон өргөтгөл, шинэчлэлт, засвар хийх барилга байгууламж, тоног төхөөрөмжийн өртгийг тодорхойлно. Төсвийн програм дээр ажиллана.

**3123-11      Иргэний ба үйлдвэрлэлийн барилгын ерөнхий хянагч**

Ажил, мэргэжлийн нэр /англиар/: Construction general supervisor

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын ерөнхий хянагч нь барилгын ажлын бүх үе шатыг хянана. Ялгаатай багуудийг зохицуулж, үүрэг даалгавар өгч, асуудлыг шийдвэрлэнэ. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт, чанарын доголдол, үл тохиролыг тухай бүрт нь засах, арилгах замаар ажлын чанарт тавих дотоод хяналтыг сайжруулна.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Барилгын хянагч

**3132-12      Операторч/Машинч, цэвэр усны насос станцын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Water treatment systems operator

Ажлын байрны тодорхойлолт: Хот суурин газрын ус хангамжийн системийн ус өргөх насос, шугам сүлжээ, ус, дулаан дамжуулах тоног төхөөрөмжийг ажиллуулах, үйл ажиллагааг нь хянах, цаг тутам насосны ажиллагааны тэмдэглэл хөтлөх ажлыг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Операторч/Машинч, цэвэр усны насос станцын
- Операторч, усан сангийн
- Ус, дулаан дамжуулах төвийн операторч

**3132-14      Операторч/Машинч, шингэн хог хаягдал боловсруулах, ус цэвэрлэх байгууламжийн, төхөөрөмжийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Liquid waste treatment plant operator



Ажлын байрны тодорхойлолт: Шингэн хог хаягдал боловсруулах, бохир ус цэвэрлэх байгууламжийн насос, тоног төхөөрөмжийн үзлэг үйлчилгээг тогтмол хийх, горимын дагуу ажиллуулах, хэвийн ажиллагааг хянах, тэмдэглэл хөтлөх ажлыг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Операторч/Машинч, түүхий үлдэцийн насос станцын
- Операторч/Машинч, идэвхит лагийн насос станцын
- Операторч/Машинч, тунгаагуурын
- Операторч/Машинч,центрфуг, декантр, туузан фильтр, дискен фильтр
- Операторч/Машинч, КУ
- Операторч, лаг усгүйжүүлэх байгууламжийн
- Операторч, лаг талбайн
- Операторч/Машинч, лаг усгүйжүүлэх урвалж бэлтгэх
- Операторч/Машинч, халдваргүйжүүлэх байгууламжийн

#### **7112-11 Угсрагч, ган болон угсармал төмөр бетон бүтээцийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Steel and prefabricated reinforced concrete structures assembler

Ажлын байрны тодорхойлолт: Өндөр болон олон давхар барилгын угсралтын ажил гүйцэтгэнэ. Төрөл бүрийн ялуу угсрах, суурийн болон ханын гулдмай (блок), хучилтын хавтан, тагт болон саравчны хавтан, төмөр бетон татанги (ферм), дам нуруу, багана угсрах бэхлэх, угсармал төмөр бетон, бүтээц эдэлхүүн тээвэрлэх, ачиж буулгах, хураах зэрэг ажил гүйцэтгэнэ.

#### **7114-18 Бетон хийцийн засалч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Concrete Polisher

Ажлын байрны тодорхойлолт: Хэвэнд цутгасан бетон хольцийг доргиулж нягтруулсны дараа дээд ирмэг, гадаргууг тэгшилж өнгөлөх, гөлийлгөх ажлыг хийнэ.

#### **7115-12 Заслын мужаан**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Carpenter

Ажлын байрны тодорхойлолт: Барилга болон бусад байгууламж барихад зориулж модон элементүүдийг зүсэж, хэлбэржүүлж, угсарна. Хуванцар, металл зэрэг материалыг ашиглана. Цонх, хаалга, хана, булан тохойн барилгын товлосон бүтээц, хэсгүүдийг суурилуулна.

#### **7119-21 Барилгын гадна дотор хуурай хийц угсрагч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Exterior and interior dry structure assembler

Ажлын байрны тодорхойлолт: Шинэ барилгын угсралт, хуучин барилгын шинэчлэл, өргөтгөл, засварыг гүйцэтгэх хүрээнд ажлын даалгавар, техникийн зураг төслийн дагуу ажлын гадаргуу болон үндсэн хийц эдлэл эмжээр хүрээг бэлтгэх, дулаан, чийг, дууны тусгаарлалт хийх, гипсэн хавтанг ажлын байранд зөөж авчрах, хэмжээсийн дагуу зүсэх, бэхлэх зэрэг ажлуудыг багаж, тоног төхөөрөмж ашиглан гүйцэтгэнэ.

**7119-22 Барилгын ажлын түр шат, тавцан угсрагч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Portable ladders and platforms assembler

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын түр шат тавцан угсрагч нь барилгын гадна талын засал чимэглэл, өнгөлгөө, будаг хийх, өрлөгийн ажил болон бусад зорилгоор барилгын гадна түр шат тавцанг угсарна. Барилгын түр шат тавцанг угсрахдаа шатны төрлийг зөв сонгох, үйлдвэрлэгчийн болон материалын сертификатыг үндэслэн тооцоолол хийх, стандартын дагуу угсрах, үзлэг оношлогоо хийх, материал, багаж хэрэгсэлд үзлэг хийнэ.

**7122-13 Мозаик шал хийгч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Mosaic floor installer

Ажлын байрны тодорхойлолт: Мозаик шал хийгч нь шалыг бетондох, арчлах, засварлах, шал, хана болон бусад гадаргууг керамик, байгалийн болон хиймэл чулуун хавтангаар гоёлын болон өөр зориулалтаар өнгөлөн бүрэх, засварлах ажлыг гүйцэтгэнэ.

**7122-20 Хивсэн материалаар шаллагч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Carpet fitter

Ажлын байрны тодорхойлолт: Шалны хучилт болгон хивсний өнхрүүлгийг тавина. Хивсээ хэмжээгээр нь огтолж, гадаргууг бэлтгэж, хивсийг тавина. Хивсэн чимэглэлийн хуурай хавтангуудыг хэмжих, тэмдэглэх, угсрах болон чимэглэлийн хүрээг зүсч бэлтгэнэ.

**7123-12 Шавардлага өнгөлгөөний ажилтан**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Plastering and finishing worker

Ажлын байрны тодорхойлолт: Баригдсан, угсрагдсан барилгын бүх төрлийн шавардлага, өнгөлгөөний ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ. Барилгад хуурай өнгөлгөөний хуудас ба хавтанцаруудыг угсрах, арчлах, засварлах, гоёлын болон хамгаалалтын зориулалтаар шавардлага хийнэ. Цемент, ижил төстэй материалаар барилгын гадна болон дотор талд шавардлагын ажлыг гүйцэтгэнэ.

Ажил мэргэжлийн жишээ:

- Барилгын чимэглэлийн хийц урлалч
- Тор тавьж шавардагч ажилчин
- Хуурай өнгөлгөөний шавардагч

**7123-15 Гадна гадаргууны шавардагч ажилчин**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: External surface plasterer

Ажлын байрны тодорхойлолт: Шохой, шохой гипсийн, цементийн, цемент шохойн зуурмагаар шавардлага хийн, хананд гөлгөр өнгөлгөө, хатуу бүрхүүл үүсгэнэ.



**7124-13 Барилгын ус чийг тусгаарлагч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Construction moisture insulator

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын суурь, зоорь, ариун цэврийн өрөөнүүд, дээвэр, ус хадгалах өрөөнүүдийн тусгаарлалтыг мэргэжлийн технологийн дагуу чанартай хийж гүйцэтгэнэ. Дээвэр, подвал, барилгын гадна, дотор хана, плитаны чигжээс, ванн, ариун цэврийн өрөө, бохирын цооног, усан бассейн, төрөл бүрийн ёмкость, агуулах, хиймэл нуур, кабелийн траншейний суваг, газар доорхи тунель зэрэг газрын ус чийг тусгаарлах ажлыг гүйцэтгэнэ.

**7126-11 Сантехникч, шугам хоолой угсрагч**

Ажил, мэргэжлийн нэр /англиар/: Plumber and pipe fitter

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын дотор сантехникийн системд хэрэглэх хуванцар (полимер) болон металлопластик (ган эсвэл хөнгөн цагаан үетэй хуванцар) хоолойн угсралтанд халаалт, халуун, хүйтэн ус дамжуулах хуванцар хоолой төлөвлөх ба угсрах барилгын норм, дүрэм, стандартын шаардлагыг баримтална.

Ажил мэргэжлийн жишээ:

- Хуванцар хоолой тайрагч
- Хуванцар CD хоолой хуйлагч

**7126-13 Сантехникч дулааны төхөөрөмжийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Heat equipment plumber

Ажлын байрны тодорхойлолт: Хэрэглэгчид, харилцагч аж ахуйн нэгж байгууллагуудаас ирсэн дуудлага, санал гомдлыг барагдуулж, засвар үйлчилгээ хийх, ус дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмж, машин механизмын аюулгүй ажиллагаа, шугам сүлжээ, түүний хаалт, арматурын хэвийн ажиллагааг хангаж, ус, дулаан болон ариутгах татуургын шугам сүлжээнд засвар үйлчилгээ хийх, гэмтлийг засварлана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Засварчин, шугам хоолой сантехникийн
- Сантехникч, засварчин, ээлжийн
- Сантехникч, засварчин дуудлагын
- Сантехникч, засварчин ашиглалтын
- Дулаан дамжуулах төв, узель угсрагч слесарь
- Уурын зуухны слесарь

**7126-16 Сантехникч, ариутгах татуургын**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Sewer plumber

Ажлын байрны тодорхойлолт: Ус, хий бохирын хоолой зайлуулах, шугам хоолой, холбогдох хэрэгсэл, усан болон хийн хөдөлгүүр зэрэг тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, засварлах, арчлах ажлыг гүйцэтгэнэ. Тоног төхөөрөмжийн хөргөлт, хүйтэн ус, халаалт, цэвэр бохир усны шугам хоолой тоног төхөөрөмжийн хөдөлт, усны алдагдал хянаж, гарсан гэмтэл дээр шуурхай арга хэмжээ авч, жигд ажиллагааг хангаж ажиллана.

**7126-17 Угсрагч, халаалт, агаар сэлгэлтийн системийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Heating and ventilation system assembler

Ажлын байрны тодорхойлолт: Хий, цахилгаан, тос, хатуу түлш болон олон төрлийн түлшээр ажилладаг халаалт, агаар сэлгэлтийн төхөөрөмжийг бие даасан халаалт, агааржуулалтын систем болгон суурилуулна, засвар үйлчилгээ хийнэ. Машин, тээврийн хэрэгсэлд суурилуулна. Заавар, төлөвлөгөөний дагуу системд засвар үйлчилгээ хийж, аюулгүй байдлыг хянана.

**7126-24 Угсрагч, гадна сантехникийн дамжуулах шугам ба хийн хоолойн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: External plumbing transmission lines and gas pipes installer

Ажлын байрны тодорхойлолт: Сантехникийн гадна шугамыг дулаална, сувгийн хана таг, худаг угсрана, бохирын болон ус зайлуулах, ус хангамжийн төв шугам, бусад зориулалтаар ухсан шуудуунд шавар, бетон, ширэмэн хоолойг угсрана.

**7126-26 Угсрагч, дотор сантехникийн систем, угсралтын /халаалт, цэвэр ус, ариутгах татуурга/**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Indoor plumbing system, installation /heating, clean water, sewerage/ installer

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын дотор талд сантехникийн шугам хоолой угсрана. Сантехникийн шугам хоолойн хаалт, хөргөлтийн ус, цэвэр, бохир ус, тоног төхөөрөмжийг хариуцаж, засварлана. Бохир ус, ариутгах татуургыг зайлуулах, зөөвөрлөх, хоолой, шахуургын станц, гол шугамыг шалгаж, гоожих, бусад гэмтэлтэй эсэхийг шалгаж, засварлана.

**7126-30 Шугам хоолойн засвар үйлчилгээний ажилтан**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Pipeline maintenance worker

Ажлын байрны тодорхойлолт: Хот суурин газрын ус хангамж, ус дулаан дамжуулан түгээх, бохир усыг татан зайлуулах шугам хоолойн засвар, үзлэг үйлчилгээг хийх, горимын дагуу ажиллуулах, хэвийн ажиллагааг хянах, тэмдэглэл хөтлөх ажлыг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Шугамын засварчин /Цэвэр ус, халаалт, бохир ус зайлуулах/
- Ашиглалтын засварчин /Гадна бохир ус зайлуулах шугам хоолойн/
- Ээлжийн засварчин /Түгээх төвийн/

**7127-11 Механикч, хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмжийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Refrigeration and ventilation equipment mechanic

Ажлын байрны тодорхойлолт: Агааржуулалтын болон агаар сэлгэлтийн систем, түүний тоног төхөөрөмжийг үзлэг үйлчилгээг хийж, горимын дагуу ажиллуулах, хэвийн ажиллагааг хянах, тэмдэглэл хөтлөх ажлыг гүйцэтгэнэ.



Ажил, мэргэжлийн жишээ:

- Техникч, тээврийн хөргөлтийн системийн
- Механикч, худалдааны хөргөх төхөөрөмжийн
- Механикч, үйлдвэрлэлийн хөргөлтийн тоног төхөөрөмжийн
- Техникч, хөргөлт агааржуулалтын менежмент

**7131-13 Будагчин, засалч хана, тааз, шалны**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Painter and plasterer of walls, ceilings and floors

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын хана болон бусад гадаргууг будах эсхүл цааслана. Дотор хана, таазыг ханын цаас, бусад бөс материалаар бүрнэ.

**7131-15 Шүршиж будагчид, лакдагчид**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Spray painter and varnisher

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын гадаргуу, тоноглолуудыг шүршиж, лакдаж будна. ,

**7133-15 Барилга байгууламжийн гадаргуу цэвэрлэгч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Building surface cleaner

Ажлын байрны тодорхойлолт: Барилгын гадна гадаргуу, бусад бүтээцийг цэвэрлэх, яндангийн хөө торгогийг цэвэрлэж, зайлуулах ажлыг гүйцэтгэнэ.

**7211-12 Операторч, хэвэнд цутгах төхөөрөмжийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Casting Equipment Operator

Ажлын байрны тодорхойлолт: Металл хайлш цутгах хэв болон голлуурыг хийнэ. Хэвийн хэсэг, хээ, суурь хавтан зэрэг ажлын эд ангиудыг хөдөлгөж зөөх, байршуулах, өргөгч кран ашиглах, ажлын эд ангиудыг зөөж хөдөлгөхөд дохио өгч, туслах ажлыг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Операторч, чийг, дулаанаар боловсруулах тоноглолын /Автоклаваас бусад/
- Металл болон пластик материалд хээ тавигч
- Шигшүүрчин, цутгамал сугалагч
- Элс хатаагч
- Шингэн шил чанагч
- Загварчин
- Загварын иж бүрдүүлэгч
- Хэв тослогч

**7212-19 Гагнуурчин, цахилгаан ба хийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Welder

Ажлын байрны тодорхойлолт: Металл бүтээгдэхүүн, эд ангийг гагнаж нийлүүлж, тасдаж засварлана. Гагнуурын төмөр хийн примус, цахилгаан хэт авианы тоног төхөөрөмж ашиглан

гагнуурын төмрийг хайлуулж, ажлын материалын төгсгөл хэсгүүдийг нийлүүлэн гагнана. Цахилгаан зүлгүүр гар багаж ашиглан гагнах материалын үзүүрүүдийг зүлгэж, тайрч, хуурайдах, тахийлгах зэргээр гагнахад бэлтгэнэ. Гагнуур хийхэд бэлтгэж гагнах материалын өнгийг шингэлж гагнах ажил хийнэ. Тоног төхөөрөмжүүдийн хэвийн жигд ажиллагаанд хяналт тавих, гарсан гэмтэл саатлыг засварлах түүнтэй холбоотой гагнуурыг чанартай түргэн хугацаанд хийж хэвийн ажиллагаанд оруулах, үзлэг үйлчилгээ хийж гэмтэл саатлаас урьдчилан сэргийлнэ. Ус дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмжийн металл эд ангиуд, инженерийн шугам сүлжээг гагнуурын аргаар засварлах, хийцийг өөрчлөх, орон сууцны байрын инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, гарсан эвдрэл гэмтлийг гагнуур хийж засварлана.

Ажил, мэргэжлийн жишээ

- Бүрэн автомат гагнуурын машины операторч
- Бүрэн автомат огтлогч машины операторч
- Цахилгаан гагнуураар арматур таслагч
- Гагнуурчин, флюсын
- Гагнуурчин, тоног төхөөрөмжийн засварчин

#### **7212-29 Үл эвдэх сорилын гагнуурчин**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Non-destructive test welder

Ажлын байрны тодорхойлолт: Нарийн гагнуур хийх боломжтой төвлөрсөн дулааны эх үүсвэрийг цацруулдаг лазер туяа ашиглан салангид металл хэсгүүдийг хооронд нь холбох зориулалттай лазер туяа, гагнуурын машиныг ажиллуулж, гагнана.

#### **7214-12 Металл хийц бэлтгэгч, угсрагч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Metal preparer and assembler

Ажлын байрны тодорхойлолт: Металл хийц бэлтгэгч, угсрагч нь барилга болон бусад байгууламжийн хүнд төмөр гулдмай, хавтанг хэвэнд оруулах ба угсрах, задлах, босгох ажлыг гүйцэтгэнэ.

Ажил мэргэжлийн жишээ:

- Хэмжээ тавигч
- Лист зүсэгч
- Тайрагч
- Металл бэлтгэгч, цүүцлэгч

#### **7215-13 Цамхагт краны оосорлогч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Tower crane rigger

Ажлын байрны тодорхойлолт: Эдлэхүүн, тоног төхөөрөмжийг зөөх, бүтээц, хэсгүүдийг байрлуулахын тулд ган татлага, олс, дүүжин уяаг оосорлох, барилгын талбайд болон бусад байгууламжид угсрах ажлыг гүйцэтгэнэ. Оосорлох төхөөрөмжийн үзлэг хийн аюулгүй ажиллагааг хангана.

Ажил мэргэжлийн жишээ:

- Багаж бэлдэц бүрдүүлэгч



- Угсралтын оосорлогч

**7223-28      Металл боловсруулах суурь машины тохируулагч, операторч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Base metalworking machine adjuster and operator

Ажлын байрны тодорхойлолт: Металл боловсруулах суурь машины багаж хэрэгслийг тохируулж, тоног төхөөрөмжийг ажиллуулна. Засвар үйлчилгээг техникийн ашиглалтын заавар, дүрмийн дагуу хийн, тоног төхөөрөмжийн жигд ажиллагааг хангана.

**7231-18      Хүнд машин механизмын механикч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Mechanic of heavy machinery

Ажлын байрны тодорхойлолт: Хүнд машин механизмын механикч-засварчин нь өөрийн мэргэжлийн хүрээний машин, механизм түүний агрегат эд ангийг угсрах, суурилуулах, тохируулах, засварлах, түүнд техникийн үйлчилгээ хийх ажлыг гүйцэтгэнэ. Машин, тоног төхөөрөмжийг үйлдвэрээс нь ирүүлсэн зааврын дагуу холбогдох журам, стандартыг мөрдөн угсарч, ажиллуулж, шалган туршиж, хүлээлгэн өгөх ажил эрхэлнэ. Бүтээгдэхүүнийг угсрах дамжлагын дагуу нэг ажилтнаас нөгөөд шилжүүлэн угсарч болно.

Ажил мэргэжлийн жишээ:

- Автомашин компьютерээр оношлогч
- Автомашины хөдөлгүүрийн засварчин, моторчин
- Тээврийн хэрэгслийн механикч-засварчин
- Дизель хөдөлгүүрийн механикч-засварчин
- Хүч дамжуулах механизмын механикч-засварчин
- Гидравлик системийн механикч засварчин
- Шалгагч механикч

**7231-19      Автомашины хөдөлгүүрийн засварчин, моторчин**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Car engine mechanic, repairer

Ажлын байрны тодорхойлолт: Үйлдвэрээс дагалдан ирсэн угсрах, тохируулах, шалгаж турших заавар, схемийн дагуу машины хөдөлгүүрийг угсарч, тохируулна. Автомашины хөдөлгүүрийн засвар үйлчилгээ хийнэ. Гар багаж, нарийн хэмжих хэрэгсэл, төхөөрөмж ашиглан оношлох, хөдөлгүүрийг задлан согог, элэгдлийг шалгаж, солино.

**8112-12      Оператор, бутлуурын /хос ротор болон нүүрсний бутлуур**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Double rotor and coal crushing operator

Ажлын байрны тодорхойлолт: Цохилт ойлтийн алхан бутлуур болон туслах тоног төхөөрөмжийг ажиллуулж, хянаана. Шохойн чулууг технологийн шаардлагын дагуу бутлана.

**8113-16      Операторч, өрмийн машины**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Drilling Operator

Ажлын байрны тодорхойлолт: Уурхайн машин, механизм, гар багаж ашиглан гүний болон ил уурхай, карьераас чулуу, ашигт малтмал, эрдэс бодис болон баялгийг олборлох ажил эрхэлнэ. Өрөмдлөгийн хазайлт, гүн, чулууны гарц өрөмдлөгийг хийнэ. Чулуу, хүдэр олборлолтыг гаргах машин, механизм, багаж тоноглолыг ажиллуулна.

Ажил мэргэжлийн жишээ:

- Экскаваторчин /ЭКГ-5А туслах/
- Шохойн чулууны карьерийн өрөмдөгч
- Өрмийн машины туслах
- Шохойн чулууны карьерийн өрөмдөгч /туслах/

#### **8182-11      Операторч, уурын тогоо, халаалтын зуухны**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Steam boiler and heating furnace operator

Ажлын байрны тодорхойлолт: Уурын хөдөлгүүр, уурын тогооны операторч нь үйлдвэр, барилга байгууламж болон хөдөлгөөнт машин, хөлгийг цахилгаан болон бусад хүчдэл, үйлчилгээгээр хангах зорилгоор төрөл бүрийн уурын хөдөлгүүр, уурын тогоо, турбин болон нэмэлт тоног төхөөрөмжийг ажиллуулж, засвар үйлчилгээ хийнэ. Халаалтын зуухны операторч нь сумын инженерийн дэд бүтцийн халаалтын тогоо, ус хангамжийн шугам сүлжээ, насос, тоноглол төхөөрөмжийн засвар, ашиглалт үйлчилгээг хариуцна.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Уурын тогоо ажиллуулагч, операторч
- Халаалтын зуухны операторч

#### **8212-12      Цахилгаан тоног төхөөрөмжийн угсрагч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Electrical equipment assembler

Ажлын байрны тодорхойлолт: Цахилгаан тоног төхөөрөмж, машин механизм, цахилгаан аппарат, тоноглолыг суурилуулах, угсрах, тохируулах, засвар, үйлчилгээ хийх ажлыг гүйцэтгэнэ. Зураг төслийн дагуу бүтээгдэхүүний эд анги, цахилгаан утсыг угсарна.

#### **8332-12      Операторч, хүнд даацын авто машины**

Ажил, мэргэжлийн нэр /англиар/: Heavy truck operator

Ажлын байрны тодорхойлолт: Хүнд даацын тээврийн хэрэгжслийг ажиллуулна. Чулуу, ашигт малтмал, бүтээгдэхүүнийг ачих, зөөх, буулгах ажлыг хариуцаж болно.

Ажил, мэргэжлийн жишээ

- Жолооч, автокраны
- Жолооч, чиргүүлтэй ачааны машин /2-3 чиргүүл трайлер/-ын
- Хүнд даацын машин, том тэрэгний жолооч

#### **8342-11      Газар шороо, зам засварын болон түүнтэй адилтгах машины операторч**

Ажил, мэргэжлийн нэр /англиар/: Earth and road maintenance equipment and other similar



## machine operator

Ажлын байрны тодорхойлолт: Газар шороо, зам засварын ажил, түүнтэй адилтгах машины операторч нь газар ухах, ангилах, тэгшлэх, нягтруулах ажлыг гүйцэтгэх машиныг ажиллуулна.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Операторч, тракторын
- Автогудропарч
- Операторч, шанагат ачигчийн
- Операторч, бетон зуурмагийн шахуургат төхөөрөмжийн
- Операторч, сэрээт өргөгч ачигч машины

### **8342-12      Гадас суулгагч машины операторч**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Stake installer machine operator

Ажлын байрны тодорхойлолт: Бетон, ган гадасыг хөрсөнд шигтгэн суулгах машиныг ажиллуулна.

### **8342-13      Операторч, бульдозерийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Bulldozer operator

Ажлын байрны тодорхойлолт: Бульдозерын операторууд шороо, чулуу, нуранга болон бусад материалыг газар дээгүүр зөөх хүнд машиныг ажиллуулна.

### **8343-11      Операторч, конвейрын гүүрэн краны, агуулахын, өргүүр сагстай өргөгчийн**

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Cranes, elevators and similar vehicles operator

Ажлын байрны тодорхойлолт: Машин механизм, өргөх төхөөрөмжийг жолоодох, чиглүүлэх, ажиллуулах, хянах, үзлэг үйлчилгээ хийх зэрэг ажил эрхэлнэ. Хөдөлгөөнт болон суурин кран бусад өргөх хэрэгслийг ажиллуулж хянана.

Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Сэрээт өргөгчийн операторч
- Гүүрэн төрлийн /гүүрэн, вандан, кабельт кран/ краны операторч
- Цамхагт краны операторч
- Манипуляторт краны операторч
- Барилгын өргүүрийн операторч
- Дүүжин зам, татах төхөөрөмжийн операторч
- Сагстай өргөгчийн операторч
- Эскалаторын операторч
- Сумт, өөрөө явагч краны операторч